

Төрийн нарийн бичгийн даргын  
2022 оны 04 дүгээр сарын 07-ний өдрийн  
67... дүгээр тушаалын 2- дүгээр хавсралт



## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Засгийн газрын 2021 оны 265 дугаар тогтоол, 2022 оны 23 дугаар тогтоол

Дагаж мөрдөх огноо:

2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Боловсрол, шинжлэх ухааны яам

Нэгжийн нэр:

Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар

Албан тушаалын нэр:

Сургалтын хөтөлбөр, үнэлгээ, төлөвлөгөө, сурах бичгийн бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ахлах түшмэл, ТЗ-9

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 44, Засгийн газрын III байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Боловсролын бүх түвшний сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээ, сурах бичгийн талаарх хууль тогтоомж, хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсөл, хөтөлбөр (сургалтын агуулга, хөтөлбөр, сурах бичиг, үнэлгээ)-ийн төсөл боловсруулах, шаардлагатай судалгаа шинжилгээ хийх, тэдгээрийг бодлогын удирдамжаар хангах, үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Засгийн газрын 2021 оны 265 дугаар тогтоол, 2022 оны 23 дугаар тогтоол

Дагаж мөрдөх огноо:

2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Боловсрол, шинжлэх ухааны яам

Нэгжийн нэр:

Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар

Албан тушаалын нэр:

Сургалтын хөтөлбөр, үнэлгээ, төлөвлөгөө, сурах бичгийн бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ахлах түшмэл, ТЗ-9

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 44, Засгийн газрын III байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Боловсролын бүх түвшний сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээ, сурах бичгийн талаарх хууль тогтоомж, хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсөл, хөтөлбөр (сургалтын агуулга, хөтөлбөр, сурах бичиг, үнэлгээ)-ийн төсөл боловсруулах, шаардлагатай судалгаа шинжилгээ хийх, тэдгээрийг бодлогын удирдамжаар хангах, үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1.Боловсролын бүх түвшний сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний чанар, нийцэл, сурах бичгийн чанар, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх хууль тогтоомж, эрх зүй, бодлогын баримт бичиг, стандарт боловсруулах;

2.Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний чанар, нийцэл, сурах бичгийн, чанар, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх урт, дунд хугацааны хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөлт хийх;

3.Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний стандарт, норм, нормативыг боловсронгуй болгох, тавигдах шаардлага боловсруулах, бодлогын удирдамжаар хангах;

4.Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний чанар, нийцэл, сурах бичгийн, чанар, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх урт, дунд хугацааны хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөлт хийхэд шаардлагатай судалгааны асуудлыг тодорхойлох;

5.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх- Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Боловсролын бүх түвшний сургалтын агуулга, хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний чанар, залгамж холбоог хангах, насан туршийн боловсролын сургалтын хөтөлбөрийн чанарыг баталгаажуулах, Мэргэшлийн үндэсний шаталсан бүтэцтэй нийцүүлэх;	Шинжилгээг цаг хугацаанд нь хийж, үр дүнг тайлагнасан, холбогдох зөвлөмжийн бодлогод тусгасан байна	Г, Х
	2.Боловсролын бүх түвшний сургалтын төлөвлөгөөний үр дүнтэй, үр ашигтай байдал, сурах бичгийн хангамж, тэгш хүртээмжийн шинжилгээ хийж санал дүгнэлт гаргах;	Шинжилгээг цаг хугацаанд нь хийж, үр дүнг тайлагнасан, холбогдох зөвлөмжийн бодлогод тусгасан байна	Г, Х
	3.Боловсролын бүх түвшний сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний чанар, нийцэл, сурах бичгийн чанар, хангамж, хүртээмжийг сайжруулах хууль тогтоомж, бодлогын төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, баталгаажуулах;	Бодлогын төслийг холбогдох эрх зүй, шаардлагын дагуу боловсруулж, цаг хугацаанд нь хэлэлцүүлсэн, батлуулсан байна.	Г, Х
	4.Боловсролын бүх түвшний	Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн	Г, Х



	сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний чанар, нийцэл, сурах бичгийн чанар, хүртээмжийг сайжруулах асуудлаар боловсролын хуулиуд болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах;	тухай хуульд заасан бүтэц, хэлбэр, эх бичвэрт тавих шаардлага хангасан байна.	
	5.Сурах бичгийн стандарт, шаардлагын төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, баталгаажуулах.	Стандарт, шаардлагын төслийг цаг хугацаанд нь боловсруулсан байна.	Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	1.Боловсролын бүх түвшний сургалтын төлөвлөгөөний үр дүнтэй, үр ашигтай байдал, сурах бичгийн хангамж, тэгш хүртээмжийн шинжилгээ хийж, урт, дунд хугацааны хөгжлийн бодлого боловсруулах чиг хандлагыг тогтоох;	Шинжилгээг цаг хугацаанд нь хийж, үр дүнг тайлагнасан, холбогдох зөвлөмжийн бодлогод тусгасан байна	Г, Х
	2.Боловсролын бүх түвшний сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний чанар, нийцэл, сурах бичгийн чанар, хүртээмжийг сайжруулах асуудлаар урт, дунд хугацааны хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөлт хийх;	Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан бүтэц, хэлбэр, эх бичвэрт тавих шаардлага хангасан байна.	Г, Х
	3.Боловсролын бүх түвшний сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээ, сурах бичгийн чанар, нийцэл, хүртээмжийн талаар Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх асуудлын төсөл боловсруулах;	Холбогдох хуульд заасан шаардлагын дагуу төслийг цаг хугацаанд нь боловсруулсан байна.	Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	1.Бүх түвшний сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээ, сурах бичгийн чанар, хүртээмжийг сайжруулах урт, дунд хугацааны бодлого, төлөвлөгөөний төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, баталгаажуулах;	Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд баримтлах зарчим, шаардлагад нийцүүлэн бодлого, төлөвлөгөөний төслийг цаг хугацаанд нь боловсруулсан байна.	Г, Х
	2.Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний чанар,	Асуудлыг бүрэн хамарсан, оновчтой томьёолон, холбогдох шаардлагыг бүрэн	Г, Х



	нийцэл, сурах бичгийн чанар, хангамж, хүртээмжийг сайжруулах зорилтыг хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөлт хийх, хэлэлцүүлэх, баталгаажуулах;	хангасан төлөвлөгөө боловсруулсан байна.	
	3.Боловсролын бүх түвшний сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээ, сурах бичгийн чанар, нийцэл, хүртээмж, сайжруулах арга хэмжээний санал, шийдлийн хувилбар боловсруулах, хэлэлцүүлэх, баталгаажуулалт хийхэд бэлтгэх;	Сайжруулалт хийх өөрчлөлт, шинэчлэлийн санал нь судалгаанд үндэслэсэн, хүрэх үр дүнг тодорхойлсон, гарч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцсон байна.	Г, Х
	4.Гадаад, дотоодын санхүүжилтээр сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний арга зүй, сурах бичгийн хүртээмжийг сайжруулах чиглэлээр урт, дунд, хугацаанд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн санал боловсруулах, хэлэлцүүлэх, баталгаажуулах;	Салбарын урт хугацааны бодлогын зорилттой уялдуулан төсөл, хөтөлбөрийн санал боловсруулсан байна.	Г, Х
	5.Мөрдөж байгаа стандарт, норм, норматив, стандартыг хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчлэх, шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хэлэлцүүлэх, баталгаажуулах.	Холбогдох шаардлага, нөхцөлийг хангасан стандарт, норм, норматив боловсруулсан, сайжруулсан байна.	Г, Х
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Боловсролын бүх түвшний сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээ, сурах бичгийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх;	Судалгаанд үндэслэсэн, олон улсын чиг хандлагад нийцүүлэн тодорхойлсон байна.	Г, Х
	2.Боловсролын бүх түвшний сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээ, сурах бичгийн талаар баримталж буй олон улсын чиг хандлагыг судлах;	Судалгаанд үндэслэсэн, олон улсын чиг хандлагад нийцүүлэн тодорхойлсон байна.	Г, Х
	3.Боловсролын бүх түвшний сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээ, сурах бичгийн өнөөгийн байдал, олон улсын чиг	Судалгаанд үндэслэсэн, олон улсын чиг хандлагад	Г, Х



	хандлагад тулгуурлан цаашид хөгжүүлэх бодлого тодорхойлох, цаашид хийх судалгааны асуудлыг тогтоох.	нийцүүлэн тодорхойлсон байна.	
5 дугаар зорилтын хүрээнд	1.Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах, дүгнүүлэх ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх;	Хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн байна.	Х, Г
	2.Яамны удирдлага, бусад нэгжээс шаардсан ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл судалгааг шуурхай, чанартай, гаргаж өгөх;	Мэдээ, мэдээллийг бодит, үнэн зөв гаргасан байна.	Г
	3.Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлж эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг "Яамны хөтлөх хэргийн жагсаалт"-ын дагуу архивын нэгж болгон хадгалуулах;	Архив албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцсэн байна.	Г
	4.Төрийн бус байгууллага иргэдтэй эрхэлсэн ажлын чиглэлээр хамтран ажиллах, зөвлөгөө, мэдээлэл өгөх.	Хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн байна.	Т, Г, Х
<b>III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА</b>			
Боловсрол	- Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй		
Мэргэжил	- Боловсрол судлал /0111/, багш /0112, 0113, 0114/		
Мэргэшил	- Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх		
Туршлага	- Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх		



Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>- сургалтын агуулга хөтөлбөр, төлөвлөгөө, арга зүй, үнэлгээ, сурах бичгийн төлөвлөлтийн аливаа асуудлыг оношлох, шалтгааныг тодорхойлох, задлан шинжлэх, бусад салбарын бодлого, төлөвлөлттэй уялдуулан зохицуулах;</li> <li>- салбарын үйл ажиллагаан дахь эрсдэлийг урьдчилан тодорхойлох, илрүүлэх, шинжлэн дүгнэх, авах арга хэмжээний хувилбар боловсруулах;</li> <li>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг оновчтой тайлагнах;</li> <li>- хяналт шинжилгээ үнэлгээ хийх, харьцуулсан судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй байх;</li> <li>- мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх;</li> <li>- баримт бичигт дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх;</li> <li>- мэдээлэл цуглуулах, нэгтгэн боловсруулах;</li> <li>- бодлогын үндэслэлтэй зөвлөмж боловсруулах;</li> <li>- бусад.</li> </ul>
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>- язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх;</li> <li>- эрхлэх асуудалд хамаарах ажил үүргийг хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн чанартай гүйцэтгэх;</li> <li>- бодит баримт нотолгоонд тулгуурлан асуудлын шийдлийн хувилбарыг боловсруулж түүний шалтгаан, үр дагаврыг тодорхойлон нэгжийн удирдлагад танилцуулах;</li> <li>- салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлаар хууль тогтоомж болон нийтийн эрх ашигт нийцсэн, оновчтой, үр дүнтэй санал боловсруулах;</li> <li>- эрхлэх асуудлын хүрээнд аливаа асуудлыг хууль болон төрийн албаны зарчимд нийцүүлэн ашиг сонирхлыг зөрчлөөс ангид шийдвэрлэх;</li> <li>- шийдлийн хувилбар, санал, мэргэшлийн зөвлөмж, зөвлөгөөний үнэн зөв байдал, үр дагаврыг хариуцах;</li> <li>- бусад.</li> </ul>
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> <li>- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа эерэг мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах;</li> <li>- бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц, ажил хэрэгч нээлттэй харилцааг бий болгох;</li> <li>- багийн зорилго, үйл ажиллагааг ойлгох, хүрээлэлд дасан зохицох, үр бүтээмжтэй ажиллах; мэдлэг туршлага ур чадвараа бусадтай хуваалцах;</li> <li>- хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг дэмждэг байх;</li> <li>- бусад.</li> </ul>
	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>- төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажлын цагийг баримтлан ажиллах;</li> <li>- харилцааны соёлыг эрхэмлэн, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;</li> <li>- ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;</li> <li>- жендэрийн эрх тэгш байдлын зарчмыг баримтлах;</li> <li>- албан ажлын чиг үүргийн дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээллээр ханган ажиллах</li> </ul>




	<ul style="list-style-type: none"> <li>чадвартай байх;</li> <li>- кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх;</li> <li>- төрийн албан хэрэг хөтлөлт, албан бичгийн боловсруулалт, монгол хэл, найруулгын чадвартай байх;</li> <li>- компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай байх;</li> <li>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх;</li> <li>- бие даан хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, шуурхай засах, дүгнэлт хийх чадвартай байх;</li> <li>- албан ажлын хүрээнд олж авсан мэдээллийг нууцлах;</li> <li>- харилцааны оновчтой арга хэлбэрийг ашиглаж, асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг шуурхай хүргэх;</li> <li>- төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах;</li> </ul>
--	---

#### IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:  
Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга

<u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>  -байхгүй	<u>Бусад харилцах субъект</u>  - Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хэлтэс, орон нутгийн харьяа газар, хэлтэс;  - Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн ажилтан;  - Иргэн, хуулийн этгээд мэргэжлийн байгууллага.
---	--

#### V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
<u>Албан тушаал:</u> АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ  /Б.ГАНТУЛГА/ (Гарын үсэг) 2022 оны ... дүгээр сарын ...-ны өдөр	Байгууллагын нэр: ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо: <b>22 03 30</b> Дугаар: <b>167</b>
Албан тушаалын тодорхойлолт баталсан	
<u>Байгууллагын нэр:</u>	





БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

Шийдвэрийн огноо: 2022.04.04

Дугаар: 8/24

(тамга/ тэмдэг)

ТӨРИЙН НАРИЙН БИЙГИЙН ДАРГА

.....



(Гарын үсэг)

/Л.ЦЭДЭВСҮРЭН/

(Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2022 оны 04 дугаар сарын 04-ны өдөр

